



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2020 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот


Ажлын задаргаа батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.4, 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/36 дугаар "Нийслэлийн 2020 оны төсөв батлах тухай" тогтоол, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын агаар, орчны бохирдлыг бууруулах ажилд судалгаа гаргах, хяналт шинэжилгээний хүрээнд үер усны гамшиг ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Хот, тохижилтын урсгал зардлаас 2020 онд санхүүжүүлэх "Геодези, Усны барилга байгууламжийн газар" ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх үерийн хамгаалалтын далан, суваг хөрсний болон борооны ус зайлуулах шугам сүлжээ, насос станцын ашиглалт, засвар, цэвэрлэгээ үйлчилгээний ажлын задаргааг хавсралт ёсоор баталсугай.

2. Засвар арчлалт, цэвэрлэгээ, ашиглалт үйлчилгээний ажлыг хууль тогтоомжийн дагуу гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Хотын инженерийн байгууламжийн хэлтэс /Т.Хэрлэн/-т даалгасугай.

3. Үерийн хамгаалалтын далан, суваг хөрсний болон борооны ус зайлуулах шугам сүлжээ, насос станцын ашиглалт, засвар, цэвэрлэгээ үйлчилгээнд зарцуулагдах 2,392,402,000 /Хоёр тэрбум гурван зуун ерэн хоёр сая дөрвөн зуун хоёр мянган/ төгрөгийг гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг дагуу Хот, тохижилтын урсгал зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2020 оны 02 дугаар сарын 24 -ны өдрийн  
тушаалын хавсралт

**ҮЕРИЙН ХАМГААЛАЛТЫН ДАЛАН, ХӨРСНИЙ БОЛОН ЗАМ ТАЛБАЙН  
БОРООНЫ УС ЗАЙЛУУЛАХ ӨРГӨЛТИЙН НАСОС СТАНЦЫН АШИГЛАЛТ,  
ЗАСВАР, ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗАДАРГАА**

№	Хийгдэх ажлын нэрс	Ажлын зардлын дүн /төгрөг/
<b>A.</b>	<b><i>Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ашиглалт, цэвэрлэгээ үйлчилгээ, засвар арчлалтын ажлын зардал</i></b>	
1	Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ашиглалт, цэвэрлэгээ үйлчилгээний ажил	1,074,204,300.0
2	Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн засвар арчлалтын ажил	1,000,000,000.0
<b>Б.</b>	<b><i>Хөрсний болон зам талбайн борооны ус зайлуулах өргөлтийн насос станцын ашиглалт, засвар арчлалтын ажил, Хөрсний усны цооногийн хяналтын ажлын зардал</i></b>	
5	Хөрсний болон зам талбайн борооны ус зайлуулах өргөлтийн насос станцын ашиглалт, засвар арчлалтын ажил	272,742,400.0
6	Мониторингийн цооногийн ашиглалт, засвар үйлчилгээний ажил	45,455,300.0
7		<b>2,392,402,000.0</b>